



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгч бөгөөд гүйцэтгэх
захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсэг, 62 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Хөтөлийн цемент шохой” ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай 124 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Хувьчлалыг хүчингүйд тооцох, компанийн эрх, эд хөрөнгийг хүлээн авах тухай” 108 дугаар тогтоол тус тус батлагдан гарсантай холбогдуулан “Цемент шохой” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлыг эрх бүхий этгээд томилох хүртэл хугацаанд захирлын үүргийг түр гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгчөөр Л.Наранбаатарыг томилсугай.

2.Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, хууль журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэгч Л.Наранбаатарт даалгасугай.

3.Компанийн Ерөнхий нягтлан бодогчийг томилохыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэгч Л.Наранбаатарт зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулан ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132007639